



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/702

Мөрөн сум


Худалдан авах ажиллагааны 2025 оны
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, аймгийн иргэдийн Төлөөлөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн III/31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтад заасан төсөл арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, зургийн даалгавар, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг аймгийн Худалдан авах ажиллагааны газарт 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т, Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn -ээр зохион байгуулж, тендерийн урилга, үр дүн, гэрээний мэдээллийг тухай бүр цахим системд нийтэлж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газар (Б.Должинсорогдог)-т тус тус даалгасугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Гандэлгэр)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Ц.ГАНСҮХ



d/zahiramj
6712012184